



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/118

Биндэр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.3, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.2.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус суманд 2024 онд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй “Соёлын төвд тавилга, тоног төхөөрөмж, хувцас хэрэглэл нийлүүлэх” ажлын гүйцэтгэлийн явцад хяналт тавих, хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Ганбат- Засаг даргын орлогч

Гишүүд: Ж.Ариунгэрэл – Соёлын төвийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Э.Эрдэнэхүү – Санхүүгийн албаны дарга

2.Дээрх ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд нь чанартай гүйцэтгүүлж холбогдох хууль журмын дагуу хүлээн авч, дүгнэлт гаргаж ажиллахыг ажлын хэсэг (С.Ганбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ЦЭНГЭЛ

Data (D:) /A4 zahiramj/

232405295